Сум хөгжүүлэх сангийн авлага оны эхэнд 197,342.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд 9 хүнд 59,000.0 мянган төгрөгийг шинээр олгож 2021 онд 118,214.6.8 мянган төгрөгийг барагдуулж оны эцэст 140,734.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй ба хугацаа 2 зээлдэгчийн 6,702.8 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн байна.

Авлага дансны 615.0 мянган төгрөг нь ЗДТГ-ын ажилчдад илүү бодож олгосон цалингийн авлага, ЗДТГ-ын зураг төсвийн үнэ 11,000.0 мянган төгрөгийг сумын ОНХС-аас авах авлага, 11,356.2 мянган төгрөг нь хувь хүмүүсээс авах өвс тэжээлийн үнийн авлага, 10,000.0 мянган төгрөг нь Соёлын төвийн "Жишиг соёлын төв" уралдаанд шалгарч БСШУЯ-наас олгогдсон шагналын мөнгө нэмэлт санхүүжилтийн дансанд орж ирсэн

боловч зарцуулалт хийгдээгүй төвлөрүүлсэн учир дараа онд авахаар авлагаар тусгасан байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 218,756.1 мянга, эцсийн үлдэгдэл 297,310.4 төгрөг болж, 78,554.4 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл* *\/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Тусгай зориулалтын материал | 49,810.1 | 51,072.5 | 1,262.4 |
| Эм боох материал | 5,011.2 | 13,448.4 | 8,437.2 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | 45,000.0 | 57,063.5 | 12,063.5 |
| Бэлэн бүтээгдэхүүн | | | 0.0 |
| Бичиг хэргийн материал | 2,649.3 | 4,387.7 | 1,738.4 |
| Аж ахуйн материал | 64,914.0 | 101,652.5 | 36,738.6 |
| Сэлбэг хэрэгсэл | 0.0 | 0.0 | 0.0 |
| Түлш, шатах тослох материал | 501.0 | 4,775.8 | 4,274.8 |
| Барилгын засварын материал | 2,677.2 | 2,899.3 | 222.1 |
| Хүнсний материал | 0.0 | 19.6 | 19.6 |
| Бусад хангамжийн материал | 35,810.9 | 56,491.1 | 20,680.2 |
| Мал амьтад | 12,382.4 | 5,500.0 | -6,882.4 |
| **Дүн** | **218,756.1** | **297,310.4** | **78,554.4** |

*Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын дансны үлдэгдэл 297,310.4 мянган төгрөг болж өмнөх оноос 78,554.4 мянган төгрөгөөр өссөн нь сумын ЗДТГ 13,393.8 мянга, ИТХ 1,160.0 мянга, Эрүүл мэндийн төв 12,863.7 мянга, хүүхдийн цэцэрлэг 6,653.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлж байна.

*Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ЗДТГ | 20,215.8 | 12,393.4 | -7,822.4 | 4.2 |
| ИТХ | 1,240.0 | 421.0 | -819.0 | 0.1 |
| Соёл | 12,852.1 | 16,282.0 | 3,429.9 | 5.5 |
| ЭМТ | 0.0 | 26,440.9 | 26,440.9 | 8.9 |
| ЕБС | 88,055.9 | 118,364.8 | 30,309.0 | 39.8 |
| Цэцэрлэг | 51,392.4 | 66,344.9 | 14,952.5 | 22.3 |
| ОНХС | 45,000.0 | 57,063.5 | 12,063.5 | 19.2 |
| СХС | | | 0.0 | 0.0 |
| **НИЙТ ДҮН** | **218,756.1** | **297,310.4** | **78,554.4** | **100.0** |

*Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд нийт нэмэгдсэн 524,544.4 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэн нь 394,166.6 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр, 550.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, бүтцийн өөрчлөлтөөр 27,908.4 мянга, 43,425.4 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар авсан байна.

*Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

| Нэмэгдсэн | 524,544.4 | Хасагдсан | 445,990.0 |
|---|---|---|---|
| Худалдан авсан | 394,166.6 | Худалдсан, зарцуулсан | 425,035.3 |
| Хандиваар | 43,425.4 | шилжүүлсэн | |
| Шилжүүлсэн авсан | 550.0 | | |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005

| | | | |
|---|---|---|---|
| Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр | 27,908.4 | бусад | 20,954.7 |
| Бусад | 58,494.0 | | |

*Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,940,067.7 мянга, эцсийн үлдэгдэл 7,862,500.4 мянган төгрөг болж 1,922,432.8 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **БИЕТ ХӨРӨНГӨ** | **5,880,727.7** | **7,788,212.4** | **1,907,484.8** | **99.1** |
| Барилга байгууламж, орон сууц | 4,698,757.3 | 6,161,246.9 | 1,462,489.6 | 78.4 |
| Тээврийн хэрэгсэл | 155,334.2 | 256,300.7 | 100,966.4 | 3.3 |
| Машин тоног төхөөрөмж | 442,223.1 | 708,367.6 | 266,144.6 | 9.0 |
| Тавилга эд хогшил | 209,378.9 | 238,899.6 | 29,520.7 | 3.0 |
| Түүх соёлын дурсгалт зүйл | 106.3 | 106.3 | | |
| Номын фонд | 32,791.8 | 33,531.8 | 740.0 | 0.4 |
| Бусад үндсэн хөрөнгө | 342,135.9 | 389,759.5 | 47,623.5 | 5.0 |
| **БИЕТ БУС ХӨРӨНГӨ** | **59,340.0** | **74,288.0** | **14,948.0** | **0.9** |
| Программ хангамж | 1,430.0 | 1,430.0 | 0.0 | 0.0 |
| Бусад биет бус хөрөнгө | 57,910.0 | 72,858.0 | 14,948.0 | 0.9 |
| **НИЙТ ДҮН** | **5,940,067.7** | **7,862,500.4** | **1,922,432.8** | **100.0** |

*Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд 1,922,432.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь сумын ЭМТ нь сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгдэн 1,742,102.0 мянган төгрөгөөр, ЗДТГ-ын хөрөнгө 71,292.3 мянга, ЕБС-ийн хөрөнгө 69,042.1 мянга, Соёлын байгууллагын хөрөнгө 25,559.7 мянга, Цэцэрлэгийн хөрөнгө 10,206.6 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалсан байна.

*Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ЗДТГ | 2,739,852.5 | 2,811,144.9 | 71,292.3 | 35.8 |
| ИТХ | 146,564.1 | 150,794.1 | 4,230.0 | 1.9 |
| Соёл | 563,028.3 | 588,588.0 | 25,559.7 | 7.5 |
| ЭМТ | 0.0 | 1,742,102.0 | 1,742,102.0 | 22.2 |
| ЕБС | 2,075,645.0 | 2,144,687.2 | 69,042.1 | 27.3 |
| Цэцэрлэг | 414,977.7 | 425,184.3 | 10,206.6 | 5.4 |
| **НИЙТ ДҮН** | **5,940,067.7** | **7,862,500.4** | **1,922,432.8** | **100.0** |

*Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нэгтгэсэн тайлангаар  мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн орлого авч, 179,393.27 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас хассан нь 98093.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, 81,300.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн бүртгэсэн байна.

*Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл* */мянган төгрөг/*

| Нэмэгдсэн | **2,101,826.04** | Хасагдсан | **179,393.27** |
|---|---|---|---|
| Худалдан авсан | 34,019.0 | Худалдсан | 0 |
| Хандиваар | 25,725.0 | Акталсан | 98,093.3 |
| Шилжүүлэн авсан | 84,672.3 | Шилжүүлсэн | 81,300.0 |
| Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр | 1,733,438.1 | | 0 |
| бусад | 183,206.9 | Бусад | 0 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ

| | | | |
|---|---|---|---|
| Дахин үнэлгээний нэмэгдэл | 40764.0 | | |

Эх сурвалж: *Баянцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 10,077.2 мянга, эцсийн үлдэгдэл 23,489.1 мянган төгрөг болж 13,411.9 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН** | **10,077.2** | **23,489.1** | **13,411.9** | **100.0** |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 10,077.2 | - | (10,077.2) | - |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 12,132.8 | 12,132.8 | 51.7 |
| Байгууллагад төлөх өглөг | - | 11,356.3 | 11,356.3 | 48.3 |
| Дүн | 10,077.2 | 23,489.1 | 13,411.9 | 100.0 |

ЭХ СУРВАЛЖ: *Баянцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөр нь сумын ЭМТ-ийн ЭМД-ын санхүүжилт дутуу орсонтой холбоотой сумын эмийн өглөг 12,132.8 мянга, сумын ЗДТГ-ын Сум дундын ойн ангид өвс тэжээлийн өглөг 11,356.3 мянга нийт 23,489.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ЗДТГ | - | 11,356.3 | 11,356.3 | 48% |
| ИТХ | - | | - | 0% |
| Соёл | - | | - | 0% |
| ЭМТ | - | 12,132.8 | 12,132.8 | 52% |
| ЕБС | 10,077.2 | | (10,077.2) | 0% |
| Цэцэрлэг | - | | - | 0% |
| ОНХС | | | - | 0% |
| СХС | | | - | 0% |
| **ДҮН** | **10,077.2** | **23,489.1** | **13,411.9** | |

Эх сурвалж: *Баянцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,532,364.5 мянга, эцсийн үлдэгдэл 6,287,741.8 мянган төгрөг болж, 1,755,377.5 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн нь Баянцагаан сумын Сум дундын эмнэлэг нь сумын Эрүүл мэндийн төв болж статусаа өөрчилсөнтэй холбоотойгоор 1,531,075.5 мянган төгрөгөөр, хуримтлагдсан үр дүнгийн данс тайлант оны хуримтлагдсан ашиг 224,301.8 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

*Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,168,230.9 | 2,453,683.7 | 285,452.9 | 39.0 |
| Өмч: - төрийн | 2,168,230.9 | 2,453,683.7 | 285,452.9 | 39.0 |
| Хуримтлагдсан үр дүн | 669,193.4 | 1,811,930.4 | 1,142,737.0 | 28.8 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,694,940.2 | 2,022,127.7 | 327,187.5 | 32.2 |
| Дүн | 4,532,364.5 | 6,287,741.8 | 1,755,377.3 | 100.0 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГ

Эх сурвалж: *Баянцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2020.12.17-ны өдрийн хуралдаанаар 2/09 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 99,100.0 мянга, хүү торгуулийн орлогыг 6,000.0 мянга, нийт 105,100.0 мянган төгрөгөөр баталсан байна.

*Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого* *//мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| 1.Татварын орлого | 99,100.0 | 122,170.6 | 23,655.6 | 123% |
| ИОТХ | 6,500.0 | 15,067.4 | 8,567.4 | 232% |
| хадгаламжийн хүүгийн орлого | 55,000.0 | 58,968.9 | 3,968.9 | 107% |
| Бууны татвар | 4,000.0 | 4,395.0 | | 110% |
| ҮХЭХ борлуулсны албан татвар | 3,000.0 | 6,005.5 | 3,005.5 | 200% |
| Улсын тэмдэгт | 3,000.0 | 1,905.1 | (1,094.9) | 64% |
| Газрын төлбөр | 1,600.0 | 916.2 | (683.8) | 57% |
| Ус рашаан | - | - | - | |
| Хог хаягдлын үйлчилгээний төлбөр | 25,000.0 | 34,892.4 | 9,892.4 | 140% |
| ТТАМАТөлбөр | 1,000.0 | 20.0 | | 2% |
| Нохойны татвар | - | | - | |
| 2.Татварын бус орлого | 6000 | 7375 | 1375 | 123% |
| 2.1.Хүү торгуулийн орлого | 6,000.0 | 7,375.0 | 1,375.0 | 123% |
| **Нийт дүн** | 105,100.0 | 129,545.6 | 25,030.6 | 123% |

*Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 25,030.6 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлого тодорхойлох хуудсаар тодорхойлсон татварын орлого 8,567.4 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 3,968.9 мянга, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 3,005.5 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 9,892.4 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин улсын тэмдэгтийн хураамж 1,094.9 мянга, газрын төлбөр 683.8 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Баянцагаан сумын татварын орлогын гүйцэтгэлийн мэдээг 127,196.0 мянган төгрөг буюу төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангаас 2,350.0 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод Засаг даргын Тамгын газар 679,9 мянга, Соёлын төвд 1,201.5 мянган төгрөгийн орлого, ОНХС-нд өвс тэжээл бусад орлого 22,050.0 мянган



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

төгрөг, СХС-ийн зээл хүүгийн эргэн төлөлтөөс 119,258.6 мянган төгрөг төлөгдөж нийт 143,190.1 мянган төгрөг орсон байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 148,000.0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 119,258.6 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

### 3.6.2 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 3,199,006.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,929,790.8 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас мянган төгрөгийг 2,775,350.3 урсгал зардалд зарцуулсан бол 154,440.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

## 3.7 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.7.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Эрүүл мэндийн системийн дээд байгууллага нь нэг хүнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөсөн ба сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020.12.17-ний өдрийн 2/09 дугаар тогтоолоор нийт 3,095,166.9 мянган төгрөгийг баталсан байна.

*Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар* *\/мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төсвийн төсөл | Анх батлагдсан төсөв | Зөрүү |
|---|---|---|---|
| Сумын ИТХ | 118,958.8 | 89,766.3 | 29,192.5 |
| ЗДТГ | 443,127.8 | 363,147.2 | 79,980.6 |
| ЭМТ | 678,905.8 | 606,875.5 | 72,030.3 |
| ЕБС | 1,105,236.2 | 1,077,983.8 | 27,252.4 |
| Цэцэрлэг | 445,638.7 | 463,644.9 | -18,006.2 |
| Соёлын төв | 108,351.2 | 95,345.5 | 13,005.7 |
| ОНХС | | 250,403.7 | -250,403.7 |
| СХС | | 148,000.0 | -148,000.0 |
| **Нийт дүн** | 2,900,218.5 | 3,095,166.9 | -194,948.4 |

*Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын хуралдааны 2020.12.17-ний өдрийн 2/09 дугаар тогтоолоор анх 3,095,166.9 мянган төгрөг, 2021.07.23-ний өдрийн 5/14 дугаар тогтоолоор 60,001.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг аймгийн Засаг даргын 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар Ерөнхий боловсролын сургуульд 23,160.0 мянга, Цэцэрлэгт 20,678.0 мянга нийт 43,838.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр сумын нийт төсөв 3,199,006.3 мянган төгрөг болсон.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ... [stamp]

Сумын ИТХ-аас 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар тусгай зориулалтын шилжүүлгийг 43,838.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байхад төсвийг тодотгон батлаагүй байна.

Нийт зардлын 1,924,585.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 195,403.7 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 646,624.7 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 105,100.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 105,000.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 66,222.0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 156,070.9 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгийн ОНХС-аас авах санхүүжилт, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 17,179.3 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авч ба улсын төсөвт 34,490.9 мянга, орон нутгийн төсөвт 25,248.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар* *\/мянган төгрөг/*

| Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | ОН-ын төсөвт төвлөрүүлсэн | Улсын төсөвт төвлөрүүлсэн |
|---|---|---|---|---|---|---|
| ИТХ | 95,216.3 | 93,521.2 | 1,695.1 | 1.0 | 1,695.1 | |
| ЗДТГ | 410,935.4 | 389,812.6 | 21,122.8 | 0.9 | 19,802.9 | |
| ЭМТ | 606,875.5 | 588,478.1 | 18,397.4 | 1.0 | | 663.9 |
| ЕБС | 1,156,781.8 | 1,150,556.8 | 6,225.0 | 1.0 | | 2,979.8 |
| Цэцэрлэг | 431,672.9 | 399,664.7 | 32,008.2 | 0.9 | | 30,847.2 |
| Соёлын төв | 99,120.7 | 93,572.0 | 5,548.7 | 0.9 | 3,750.2 | |
| ОНХС | 250,403.7 | 154,440.5 | 95,963.2 | 0.6 | | |
| СХС | 148,000.0 | 59,745.0 | 88,255.1 | 0.4 | | |
| **Нийт дүн** | **3,199,006.3** | **2,929,790.8** | **269,215.5** | **6.8** | **25,248.2** | **34,490.9** |

*Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,929,790.8 мянган төгрөг буюу 91.5 хувьтай байгаа нь Цэцэрлэг нь ковид цар тахалтай холбогдуулан хоолны зардлыг 17,312.2 мянга, байр ашиглалтын тогтмол зардлыг 1,161.0 мянга, цалин, НДШ-ийн зардлыг 13,498.0 мянган төгрөгөөр хэмнэсэн, сумын ЗДТГ нь тайланд онд цалингийн зардал 16,210.8 мянга, ЭМНДШ-ийн зардал 2,897.6 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 60.9 мянга, томилолтын зардал 1,515.4 мянган төгрөгөөр хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажил 154,440.5 мянган төгрөг, СХС-аас олгох зээлийг 59,000.0 мянган төгрөгөөр олгосноос 184,218.3 мянган төгрөгийн төсвийг зарцуулаагүйгээс хэмнэлт үүссэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7.2 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 305,931.1 мянган төгрөг төвлөрснөөс дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 123,394.6 мянга, эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлогоос 75,636.0 мянга, Эрүүл мэндийн төвийн үндсэн үйл ажиллагааны орлого 105,900.5 мянга, Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын ИТХ-д 1000.0 мянган санхүүжилт тус тус орсон байна.

Гүйцэтгэлээр тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 21,039.0 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 95,017.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 144,183.6 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулалт 35,433.3 мянган төгрөгийг зарцуулж 10,257.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа* /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | ИТХ | ЗДТГ | ЕБС | Цэцэрлэг | Соёл | ЭМТ | НИЙТ |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НИЙТ ОРЛОГО** | **1,000.0** | **34,041.2** | **75,802.5** | **3,550.9** | **10,000.0** | **181,536.5** | **305,931.1** |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000.0 | | | | | | 1,000.0 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 34,041.2 | 75,802.5 | 3,550.9 | 10,000.0 | 0.0 | 123,394.6 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | | | | | 105,900.5 | 105,900.5 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | | | | | | 75,636.0 | 75,636.0 |
| **НИЙТ ЗАРЛАГА** | **1,000.0** | **34,041.2** | **75,571.3** | **3,524.3** | **0.0** | **181,536.5** | **295,673.3** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,000.0 | 34,041.2 | 9,347.8 | | | 99,794.6 | 144,183.6 |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | | | | | | 35,433.3 | 35,433.3 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | | 21,039.0 | | | | 21,039.0 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | | 45,184.5 | 3,524.3 | | 46,308.6 | 95,017.4 |

## 3.8 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 79 мэдээллээс 74 мэдээллийг хугацаанд нь, аудитын тайлан, хагас жилийн санхүүгийн тайлан, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт зэрэг 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

### 3.9. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг аудитор Н.Бунчинсүрэн гүйцэтгэж, 81,000.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэхдээ хуулийн хугацаанд мэдээлээгүй зөрчил давтагдан гарсан байна.

## 4. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт, сумын ЗДТГ-т “Хязгаарлалтай” санал дүгнэлт хүргүүлж, сумын ИТХ, Соёл, СХС, ОНХС-ийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагааг түүвэрт хамруулан шалгасан.

*Хүснэгт 17* *ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн дүгнэлт*

| № | Байгууллагын нэр | Аудит хийсэн байгууллагын нэр | Дүгнэлтийн хэлбэр |
|---|---|---|---|
| 1 | Засаг даргын Тамгын газар | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар | Хязгаарлалттай |
| 2 | Ерөнхий боловсролын сургууль | | Зөрчилгүй |
| 3 | Эрүүл мэндийн төв | "Баян ташаагийн эх аудит" ХХК | Зөрчилгүй |
| 4 | Цэцэрлэг | | Зөрчилгүй |
| 5 | Иргэдийн төлөөлөгчийн хурал | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар | Түүвэрт хамрагдсан |
| 6 | Соёлын төв | | Түүвэрт хамрагдсан |
| 7 | Орон нутгийн хөгжлийн сан | | Түүвэрт хамрагдсан |
| 8 | Сум хөгжүүлэх сан | | Түүвэрт хамрагдсан |

Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан, мөн АДБОУС 1240 (АОУС 240) дагуу сонгосон горим сорилоор доорх алдаа зөрчил илэрч

- Тайлант онд шилжиж ирсэн 25,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий Лексус-470 маркийн автомашин нь банк бус санхүүгийн байгууллагын нэр дээр эзэмшлийн гэрчилгээтэй.
- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгө оруулалтаар ирээд 3 жил болоогүй TLC 200 автомашин засвар үйлчилгээ, зогсоолын төлбөр 8,149.9 мянган төгрөгийг төсвөөс гаргасанд төсөвт буцаан төлүүлж төсөвт учирсан хохирлыг арилгахаар өгсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй,
- Тайлант онд шилжиж ирсэн, өөрийн эзэмшилд шилжээгүй дээрх Лексус-470 автомашинд 7,000.0 мянган төгрөгийн засвар хийсэн зэрэг нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болжээ.

Харьяа байгууллагуудын төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 616,190.1 мянган төгрөгийн 15 алдаа, зөрчил илрүүлснээс 28,800.0 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 1,817.2 төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 87,000.0 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага өгч, 498,572.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 10 зөвлөмжийг хүргүүлжээ. Үүнээс нийцлийн аудиттай холбоотой зөрчлийг давтан гаргахгүй байх 497,227.8 мянган төгрөгийн 9 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

*Хүснэгт 18 ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил* /мян.төг/

| Байгууллагын нэр | Нийт алдаа зөрчлийн дүн | | Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Залруулга | | Тогтоосон төлбөрийн акт | | Өгсөн албан шаардлага | | Өгсөн зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Санхүүгийн тайлангийн зөрчил** | | | | | | | | | | |
| Ерөнхий боловсролын сургууль | 1 | 28,800.0 | 1 | 28,800.0 | | | | | | |
| Хүүхдийн цэцэрлэг | 0 | - | | | | | | | | |
| ЗДТГ | 4 | 35,162.3 | | | 1 | 1,817.2 | 2 | 32,000.0 | 1 | 1,345.1 |
| ОНХС | 1 | 55,000.0 | | | | | 1 | 55,000.0 | | |
| Эрүүл мэндийн төв | 0 | - | | | | | | | | |
| Сум хөгжүүлэх сан | 0 | - | | | | | | | | |
| СТА зөрчлийн дүн | 6 | 118,962.3 | 1 | 28,800.0 | 1 | 1,817.2 | 3 | 87,000.0 | 1 | 1,345.1 |
| **СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал** | | | | | | | | | | |
| Ерөнхий боловсролын сургууль | 3 | 168,726.6 | | | | | | | 3 | 168,726.6 |
| Хүүхдийн цэцэрлэг | 2 | 49,382.8 | | | | | | | 2 | 49,382.8 |
| ЗДТГ | 2 | 96,395.1 | | | | | | | 2 | 96,395.1 |
| Иргэдийн төлөөлөгчийн хурал | 0 | - | | | | | | | | |
| Соёл | 0 | - | | | | | | | | |
| Эрүүл мэндийн төв | 1 | 140,762.6 | | | | | | | 1 | 140,762.6 |
| ОНХС | 1 | 41,960.7 | | | | | | | 1 | 41,960.7 |
| Нийцлийн аудитын дүн | 9 | 497,227.8 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 9 | 497,227.8 |
| Нийт дүн | 15 | 616,190.1 | 1 | 28,800.00 | 1 | 1,817.2 | 3 | 87,000.0 | 10 | 498,572.9 |

| **Харьяа төсвийн байгууллагуудын дүн** | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Ерөнхий боловсролын сургууль** | | | | | |
| 1 | Санхүүгийн тайланд бие бус хөрөнгийн зардлыг 28,800.0 төгрөгөөр дутуу тайлагнасан байна. | 28,800.0 | Санхүүгийн тайлангийн Мөнгөн гүйлгээний тайланд залруулга хийв. | Дарга, нягтлан бодогч | С.Нандинцэцэг, Г.Наранчимэг |
| 2 | Боловсролын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ой арга хэмжээний зардалд 500.0 мянга, гүйлтийн зам авах зардалд 1,800.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. | 2,300.0 | Цаашид Засгийн газрын тогтоол болон дээд шатны байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг мөрдөн ажиллах зөвлөмж хүргүүлэв. | Дарга, нягтлан бодогч | С.Нандинцэцэг, Г.Наранчимэг |
| 3 | Тайлант онд тогтмол зардалд 122,019.5 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 24,403.9 мянган төгрөг байна. Тус онд 3,245.1 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн бөгөөд 24,400.6 мянган төгрөгийн хэмнэлтийг үүсгээгүй байна. | 24,400.6 | Цаашид Засгийн газрын тогтоол болон дээд шатны байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг мөрдөн ажиллах зөвлөмж хүргүүлэв. | Дарга, нягтлан бодогч | С.Нандинцэцэг, Г.Наранчимэг |
| 4 | Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл мэдээлбэл зохих 149 мэдээллээс тухай бүр оруулахаас 142,026.0 мянган төгрөгийн 12 | 142,026.0 | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар заалтыг хэрэгжүүлэн ажиллах | Дарга, нягтлан бодогч | С.Нандинцэцэг, Г.Наранчимэг |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна | | | | |
| | **ДҮН** | **197,526.6** | | | |
| **Засаг даргын Тамгын газар** | | | | | |
| 1 | Ажилтан, албан хаагчдын цалинг төрийн албаны нэгдсэн системд амралт бодож олгохдоо 1,817.2 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна. | 1817.2 | Давхардуулан олгосон 1,817.2 мянган төгрөгийн амралтын цалинг нэр бүхий 5 албан хаагчдаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов | Дарга, нягтлан бодогч | М.Чинбат, Г.Түмэнболд |
| 2 | Аж ахуйн материал 565.0 мянга, Түлш шатахууны зардалд 230.1 мянга, бусад хангамжийн материал 550.0 мянга, нийт 1,345.1 мянган төгрөгөөр тайланг зөрүүтэй тайлагнасан байна. | 1,345.1 | Дутуу тайлагнасан 1,345.1 мянган төгрөгийн тайланг үнэ зөв гаргаж эхний хагас жилд багтаан шалгуулах. | Дарга, нягтлан бодогч | М.Чинбат, Г.Түмэнболд |
| 3 | Тайлант онд шилжиж ирсэн 25.0 сая төгрөгийн үнэ бүхий Лексус-470 маркийн автомашин нь банк бус санхүүгийн байгууллагын нэр дээр эзэмшлийн гэрчилгээтэй байна. | 25,000.0 | Баянцагаан сумын ЗДТГ-т эзэмшүүлсэн Лексус-470 маркийн автомашины эзэмшлийн гэрчилгээг холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулж, өөрийн эзэмшлийн нэр дээр шилжүүлэн авах албан шаардлага хүргүүлэв | Дарга, нягтлан бодогч | М.Чинбат, Г.Түмэнболд |
| 4 | Өмнөх онд зөвлөмжөөр хөрөнгө оруулалтаар ирээд 3 жил болоогүй TLC 200 автомашин засвар үйлчилгээ, зогсоолын төлбөр 8,149.9 мянган төгрөгийг төсвөөс гаргасанд төсөвт буцаан төлүүлж төсөвт учирсан хохирлыг арилгахаар өгсөн байхад тайлант онд шилжиж ирсэн, өөрийн эзэмшилд шилжээгүй хөрөнгөд 7,000.0 мянган төгрөгийн засвар хийж зөрчлийг давтан гаргасан байна | 7,000.0 | Тайлант онд зарцуулсан 7000.0 мянган төгрөг болон өмнөх оны 8149.9 мянган төгрөгийн хохирлыг барагдуулах арга хэмжээг хуулийн байгууллагад өгч шийдвэрлүүлэх албан шаардлага өгөв. | Дарга, нягтлан бодогч | М.Чинбат, Г.Түмэнболд |
| 5 | Тайлант хугацаанд оруулбал зохих 493,678.8 мянган төгрөгийн үнийн дүнтэй 151 мэдээллийг байршуулахаас 402,170.6 мянган төгрөгийн 116 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бол Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 91,507.8 мянган төгрөгийн 35 мэдээг хугацаа хоцроож байршуулсан | 91,507.8 | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээг цаг хугацаанд нь байршуулж байх. | Дарга, нягтлан бодогч | М.Чинбат, Г.Түмэнболд |
| 6 | Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 26,986.1 мянган төгрөгөөр, тодотголоор 26,537.0 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 26,476.2 мянган төгрөг зарцуулж Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8 [1] дэх заалтаар 20 хувь буюу 5,397.2 мянган төгрөг хэмнэхээс 509.9 мянган төгрөг буюу 1.2 хувь хэмнэсэн нь тогтоолыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна. | 4,887.3 | Цаашид Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол, журмыг хэрэгжүүлэн ажиллах | Дарга, нягтлан бодогч | М.Чинбат, Г.Түмэнболд |
| | **ДҮН** | **131,557.4** | | | |
| **Цэцэрлэг** | | | | | |
| 1 | Баянцагаан сумын Цэцэрлэг нь 2021 онд нийт 399,664.6 мянган төгрөгийн 27 төрлийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээ мэдээллийн хугацаа нь болоогүй, 119 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 35,281.7 мянган төгрөгийн 30 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна | 35,281.7 | Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлж цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх гэсэн зөвлөмж өгөв. | Дарга, нягтлан бодогч | |

[1] байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 17,728.6 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 16,567.5 мянган төгрөг зарцуулсан нь тогтмол зардлын 20 хувь бууруулах буюу 14,101.1 мянган төгрөгийн хэмнээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалттай нийцэхгүй байна. | 14,101.1 | Цаашид байгууллагын удирдлага гаргасан тогтоол, журам, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах. | Дарга, нягтлан бодогч | |
| | **ДҮН** | **49,382.8** | | | |
| **Эрүүл мэндийн төв** | | | | | |
| 1 | 2021 онд нийт 770,014.0 мянга төгрөгийн 17 төрлийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээ мэдээллийн хугацаа нь болоогүй, 93 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 140,762.6 мянган төгрөгийн 24 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна | 140,762.6 | Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлж цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв | Дарга, нягтлан бодогч | М.Даваахүү, П.Эрдэнэчимэг |
| | **ДҮН** | **140,762.6** | | | |
| **Орон нутгийн хөгжлийн сан** | | | | | |
| 1 | Баянцагаан сумын ОНС-гийн хөрөнгөөр Буянт хөрс наран ХХК-аас 55.0 сая төгрөгөөр Ковш автомашин худалдан авах гэрээг 2021.09.20-ны өдөр байгуулж хөрөнгийг худалдан авсан байна. Аудитаар хог тээврийн зориулалттай автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь байгууллагын эзэмшилд шилжиж ирээгүй байна. | 55,000.0 | Авто тээврийн тухай хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1 дэх заалтыг зөрчсөн тул зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж байна. | Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Н.Гансүх, Д.Аюуш |
| 2 | Шилэн дансны тухай хуулийн 6.4.3 т заасан 41960.7 мянган төгрөгийн 1 мэдээллийг хоцроосон | 41,960.7 | Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн 6.4.3 дахь заалтыг хуулийн хугацаанд мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв. | Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Н.Гансүх, Д.Аюуш |
| | **ДҮН** | **96,960.7** | | | |
| **Төсвийн шууд захирагчийн тайлангийн алдааны дүн** | | **616,190.1** | | | |

## 4.1 Аудитын илрүүлэлт

Төвлөрүүлэн захирагчид 46,188.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 5 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

### 4.1.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

1.Илрүүлэлт: Баянцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр төсвийн захирагчийн хэрэгжүүлсэн хөтөлбөр, хүрэх үр дүнг хэрэгжүүлсэн эсэх талаарх төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ИТХ-аар төсвийг хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүнгийн зорилттой уялдуулан батлуулж жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр гаргаж тайлбар танилцуулгын хамт ирүүлж байх.

2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

2.Илрүүлэлт :Тус сумд тусгай зориулалтын шилжүүлгээс олгох санхүүжилтийг аймгийн Засаг даргын 2021 оны А/742 дугаар захирамжаар 43,838.0 мянган төгрөгөөр

нэмэгдүүлснийг сумын ИТХ-ын тогтоолоор нэмж тодотгоогүй төсвийн гүйцэтгэлийн тайлан сумын ИТХ-ын тогтоолоос 43,838.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх хэсэгт "Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон" гэсэн заалтын хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын Засаг дарга дээд шатны төсөв захирагчаас төсөвт өөрчлөлт оруулсан тохиолдолд төсвийн тодотголыг боловсруулж сумын ИТХ-д өргөн мэдүүлж төсөвт тодотгол оруулж байх.

3.Илрүүлэлт: Тухайн сумын Төсвийн Ерөнхийлөн захирагч Баянцагаан сумын Засаг даргын тайланд нэгтгэгддэг төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сулаас 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 616,190.1 мянган төгрөгийн 15 алдаа, зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.10 дахь заалтыг мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

4.Илрүүлэлт: Тус сумын ОНЕО-ын дансанд сумд төвлөрөх татварын орлогоор 129,545.6 мянган төгрөг төвлөрсөн ч Татварын хэлтэст 127,195.6 мянган төгрөг буюу 2,350.0 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн аудитын "үнэлгээ ба хуваарилалт", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын орлогын мэдээг Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлагнасан орон нутгийн орлогын мэдээтэй тохируулан зөрүүгүй гаргах.

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

5.Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 79 мэдээллээс 74 мэдээллийг хугацаанд нь, аудитын тайлан, хагас жилийн санхүүгийн тайлан, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт зэрэг 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална" гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

## 5. Хавсралт 1. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Баянцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2022.03.25 | | | БНА-2022/16/НА-СТА-ТТЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Баянцагаан сумын Засаг дарга | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | **1.Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлан** | | | | |
| 1 | Тус сумд тусгай зориулалтын шилжүүлгээс олгох санхүүжилтийг аймгийн Засаг даргын 2021 оны А/742 дугаар захирамжаар 43838.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснийг сумын ИТХ-ын тогтоолоор нэмж тодотгоогүй төсвийн гүйцэтгэлийн тайлан сумын ИТХ-ын тогтоолоос 43838.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. | 43,838.0 | Төсвийн тодотголыг боловсруулж тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал өргөн мэдүүлж төсөвт тодотгол оруулж батлах зөвлөмж хүргүүлэв. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Н.Гансүх, Д.Аюуш |
| 2 | Тус сумын ОНЕО-ын дансанд сумд төвлөрөх татварын орлогоор 129545.6 мянган төгрөг төвлөрсөн ч Татварын хэлтэст 127195.6 мянган төгрөг буюу 2350.0 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна. | 2,350.0 | Татварын орлогын мэдээг Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлагнасан орон нутгийн орлогын мэдээтэй тохируулан зөрүүгүй гаргах зөвлөмж хүргүүлэв | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Н.Гансүх, Д.Аюуш |
| 3 | Баянцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр төсвийн захирагчийн хэрэгжүүлсэн хөтөлбөр, хүрэх үр дүнг хэрэгжүүлсэн эсэх талаарх төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлээгүй байна | - | Сумын ИТХ-аар төсвийг хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүнгийн зорилттой уялдуулан батлуулж жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр гаргаж тайлбар танилцуулгын хамт ирүүлж байх зөвлөмж хүргүүлэв | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Н.Гансүх, Д.Аюуш |
| 4 | Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 79 мэдээллээс 74 мэдээллийг хугацаанд нь, аудитын тайлан, хагас жилийн санхүүгийн тайлан, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт зэрэг 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна | - | Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж хуулийн хугацаанд мэдээг байршуулж байх зөвлөмж хүргүүлэв | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Н.Гансүх, Д.Аюуш |
| 5 | Тухайн сумын Төсвийн Ерөнхийлөн захирагч Баянцагаан сумын Засаг даргын тайланд нэгтгэгддэг төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сулаас 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 616,190.1 мянган төгрөгийн 15 алдаа, зөрчил илэрсэн байна | | Төсвийн тухай хуулийн 14.2.10 дахь заалтыг мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэв. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Н.Гансүх, Д.Аюуш |
| | **Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангийн алдааны дүн** | **46,188.0** | | | |

---oOo---



ТӨРИЙН АУДИТЫН БАЙ... ЗӨРЧЛИЙГ ... 006